



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 3/06

Ховд

Ажил хариуцуулах тухай

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбатад хариуцуулсугай.

2. Шинээр хариуцсан ажил үүргийг албан тушаалын тодорхойлолтын дагуу Авлигын эсрэг хууль тогтоомж, холбогдох журмыг мөрдүүлж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн /Ч.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3. Ч.Эрдэнэбатад мөн өдрөөс эхлэн албан тушаалын цалингийн 20 хувийн нэмэгдлийг сар бүр бодож олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаалыг гарсантай холбогдуулан 2013 оны Б/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД